



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/119

Улаанбаатар хот

Г Боловсролын хэлтсийн бүтэц, орон тоог
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/125 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Боловсролын газрын орон тооны жишиг, дүүргийн Боловсролын хэлтсийн орон тооны жишиг батлагдсантай холбогдуулан дүүргийн Боловсролын хэлтсийн бүтэц, орон тоог шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Шинэчилсэн бүтэц, орон тооны дагуу батлагдсан цалингийн санд багтаан үйл ажиллагаагаа зохион байгуулж ажиллахыг Боловсролын хэлтэс (Ш.Баасансүрэн) үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа) даалгасугай.


4. Энэ захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/222 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЭРДЭНЭБАЯР

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2022 оны... сарын... ны өдрийн... дугаар
захирамжийн хавсралт



БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН ШИНЭЧЛЭН БАТАЛСАН БҮТЭЦ,
ОРОН ТООНЫ ЖАГСААЛТ

№	Албан тушаал	Бүтэц, орон тоо
1	Дарга	1
2	Сургалтын арга зүй, багшийн мэргэжлийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3	Төсвийн төлөвлөлт, статистик, хөрөнгө оруулалт, гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн	1
4	Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалал, сургалтын орчин, сурах бичиг, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1
	Нийт	4